



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 013/13

Улаанбаатар хот


**Тогтоолын хэрэгжилт ханган
ажиллах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг шинэчлэн тогтоох тухай”-ын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн өмчит Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нийслэлийн өмчийн байр талбайг түрээсийн гэрээгээр эзэмшиж буй түрээслэгчдийн 2019-2020 оны хичээлийн жилд түрээсийн талбайн 1м.кв талбайн үнийг тус бүр 5,000 /таван мянган/ төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсугай.

2. Дээрх ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулж 2019 оны 09 дүгээр сарын 25-ны дотор гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ